

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны
2024 оны 04 сарын 25-ны өдрийн
110... албан бичгийн хавсралт

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2024 ОНЫ
4 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хугацаа	Биелэлт
1	Хугацаатай мэдээ, тайлан гаргах	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг	Дараа сарын 02-ны дотор	2024 онд манай байгууллагад 78,616.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 54,838.8 мянган төгрөгийг зарцуулж, 23,777.2 мянган төгрөг тайлант хугацаанд зарцуулагдаагүй байна.
		Шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах	Дараа сарын 08-ны дотор	Тайлант хугацаанд оруулбал зохих 10 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулсан.
		Ниймгийн даатгалын тайлан гаргаж, хүргүүлэх	Дараа сарын 05-ны дотор	3-р сарын НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд илгээж, тайлагнасан.
2	Сум дундын ойн ангийн 2023-2024.02 сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	04 сар	Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь давтамжтай буюу 2-р түвшин"-д байна гэж үнэлэгдсэн ба дотоод аудитаар илэрсэн 7 асуудлаас 5 нь буюу 71.4% нь нөлөө ихтэй "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлтийг өгч, байгууллагад 15 заалт бүхий хугацаатай зөвлөмжийг өгөв. "Сум дундын ойн анги" ТБАГ нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам боловсруулаагүй, дотоод хяналт шалгалтыг эрсдэлтэйгээ уялдуулан зохион байгуулах, байгууллагын эрсдэлийг үнэлж эрэмбэлэх шаардлагатай байна. Дотоод хяналтын тогтолцооны төлөвшлийн үнэлгээгээр хангалтгүй гэж үнэлэгдсэн тул дотоод хяналтын ажлыг эрчимжүүлэх талаар арга хэмжээ авч, үр дүнг тооцож, гүйцэтгэх удирдлага хяналт тавих хэрэгтэй. Мөн албан хаагчдын ажил үүргийн хуваарилтыг оновчтой зохион байгуулахгүй байна. Үүнээс шалтгаалан байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, дотоод хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж чадахгүй байна. Тус байгууллагын албан хаагчид нийгмийн баталгаа, ажиллах нөхцөл

				боломжоор хангагдахгүй байгаа нь төсөвт цалин сан болон шаардлагатай бусад зардлын төсвийг хангалттай тавьж өгөхгүй байгаагаас шалтгаалан тус байгууллага нь чадварлаг ажилтан авах, хөгжүүлэх болон хадгалахад чиглэсэн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж чадахгүй байна.
3	Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023-2024.03 сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	4 сар	Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 04 дүгээр удирдамжийн дагуу Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг 04 дүгээр сарын 16-ны өдөр эхлүүлээд байна. Аудитын явц 30 хувьтай үргэлжилж байна.
4	Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-ын 2023-2024.03 сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	4 сар	Байгууллагын засаглал, дотоод хяналтын тогтолцооны түвшин 59 хувь нь 2-р түвшин буюу ДАВТАМЖТАЙ, үнэлэгдсэн ба дотоод аудитаар илэрсэн 11 асуудлаас 7 нь нөлөө ихтэй буюу "Сайжруулах шаардлагатай" дүгнэлтийг өгөв. Дотоод аудитаар илэрсэн 11 асуудлаас 3 дутагдлыг дотоод аудитын явцад зөвлөмж өгч арилгуулав. 1 дутагдалд газар нь зөвлөмж өгч цаашид сайжруулж анхаарах шаардлагатай зөвлөв. 7 дутагдлыг арилгуулах 26 заалт бүхий хугацаатай зөвлөмжийг өгөв. Байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийн үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдсэн байгаа нь эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон үйл явц тогтоогүй, эрсдэлийг үл хайхрах, эрсдэлийг эрэмбэлэх, нэн чухал ач холбогдолтой эрсдэлийг бууруулах арга хэмжээг авахгүй байснаас зорилго зорилтоо хангаж ажиллаж чадахгүй байгаа нь хяналт шалгалтын байгууллагуудаас хийсэн шалгалтын дүн, авлага, өр төлбөр, акт торгууль, хөрөнгийн алдагдал хүлээх зэрэг урьдчилан сэргийлэх боломжтой эрсдэлүүд жил бүр давтагдан гарч байгаагаас харагдаж байна. Сүмбэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар тогтоолоор Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-ын ажиллах дүрмийг баталсан ч 2019 оноос хойш нэмэлт өөрчлөлт ороогүй. Засаглах болон гүйцэтгэх удирдлага хоорондоо хараат бус боловч Засаглах удирдлагаас гүйцэтгэх удирдлага байгууллагын зорилгыг тодорхойлох, стратеги, бүтэц, үйл ажиллагааны төлөвлөгөө ба төсөв, үйл ажиллагааны гүйцэтгэл үр дүн зэрэгт хяналт тавьдаггүй. Байгууллагын

				ажиллах дүрэмд гүйцэтгэх удирдлага дотоод хяналтын системийг бүрдүүлэх талаар засаглах удирдлагын өмнө хариуцлага хүлээх, дотоод хяналтын тогтолцоог хэрхэн хянах талаар тусгагдаагүй байгаа нь дүрэмд хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.
5	ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 2023-2024.03 сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	4 сар	Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 03 дугаар удирдамжийн дагуу ЕБ-ын 1 дүгээр сургуульд дотоод аудитыг 04 дүгээр сарын 16-ны өдөр эхлүүлээд байна. аудитын явц 45 хувьтай үргэлжилж байна.
6	Аймгийн ОНХСангийн 2022-2024 оны 3 дугаар сар хүртлэх санхүүгийн үйл ажиллагаа	Санхүүгийн сахилга бат сайжирна	04 сар	Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Аймгийн ОНХСангийн 2022-2024 оны 3 дугаар сар хүртлэх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалтын явц 40 хувьтай байна.
7	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах	Хуулийн хэрэгжилт хангагдана	04 сар	Шивээговь сумын ИТХ, Сүмбэр сумын ЗДТГазрын 1-3 дугаар сар, 4, 5, 6 дугаар цэцэрлэгийн 1-3 дугаар сарын тогтмол зардлын шилэн дансны мэдээллийг үнэн зөв оруулсан эсэхэд баримтын шалгалт хийлээ. Шалгалтаар 4,5,6 дугаар цэцэрлэгүүд тогтмол зардлаа, Шивээговь сумын ИТХ гэсэн байгууллагууд нь шилэн дансны мэдээллээ үнэн зөв, бүрэн мэдээлэлсэн бол Сүмбэр сумын ЗДТГазарт зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан тоот хүргүүлэв. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 50 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 3 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдалд хяналт шалгалт хийсэн бөгөөд хуулийн хэрэгжилт 99.4 хувьтай байна. Энэ нь өмнөх сараас 1.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
8	Мэдээллийн ил тод байдлыг хангах	Мэдээллийн ил тод байдал хангагдах	04 сар	Мэдээллийн ил тод байдлыг хангаж, ойлгомжтой байлгах үүднээс байгууллагын веб хуудас болон самбарт 7 мэдээ мэдээллийг байршуулсан. Байгууллагын facebook хуудс https://www.facebook.com/profile.php?id=100090091147081/ -аар 11 мэдээллийг иргэд олон нийтэд түгээж ажиллалаа.

9	Бусад ажил	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна.	04 сар	1. Аймгийн удирдах ажилчдын шуурхай зөвлөгөөний 3 удаагийн хурлаас өгсөн 7 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн.
				2. 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хуваарилсан талбай болох Аймгийн Засаг даргын Тамгын газрын зүүн талын явган хүний зам, 5 дугаар цэцэрлэг хүртэлх явган замын ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэсэн.
				3. Монгол Улсын Шадар сайдын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр баталсан "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний удирдамж"-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр аймгийн Онцгой байдлын газраас "Газар хөдлөлтийн тухай ойлголт, түүхэнд тохиолдсон хүчтэй газар хөдлөлт" сэдвээр Стандарт хэмжилзүйн хэлтэс, Статистикийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газруудтай хамтарч сургалт авсан. Сургалтад нийт 19 албан хаагч хамрагдсан.
				4. 2024 оны 04 сарын 17-ны өдөр "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хариуцсан талбайд мод арчилгаа, усалгааг хийх бэлтгэл ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. Орчны хог хаягдлыг цэвэрлэж хогийн цэгт хаясан. 2. Хариуцсан талбайн модны нүхний тогоог засч шинээр хийж услах бэлтгэл ажлыг бүрэн хийсэн.
				5. 2024 оны 04 сарын 18-ны өдөр хариуцсан талбайн модыг усалсан.
				6. 2024 оны 04 сарын 24-ний өдөр байгууллагын ойр орчмын 50м хүртэлх талбайн хог хаягдлыг цэвэрлэн Хоггүй сүмбэр фэйсбүүк хуудас болон пэйж хуудсанд байршуулсан.
				7. Төрийн албаны салбар зөвлөлийн "7:4:10" сургалтын хөтөлбөрийн дагуу 2024 оны 04 дугаар сарын 4, 11, 18-ны өдрийн вебинар сургалтад 4 албан хаагч хамрагдсан.
				8. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс "АЗ ЖАРГАЛЫН ИНДЕКС-БҮТЭЭГЧ" АВЛИГАГҮЙ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ БИ" аяныг амжилттай зохион

				байгууллаа. Тус аянд 16 төрийн байгууллагын 59 албан хаагч нэгдсэн.
				9. Хүүхэд хамгааллын тухай хууль болон нийгмийн даатгалын багц хуулийг танилцуулах сургалтанд хамрагдав.
				10. 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт 1 албан хаагч хамрагдсан.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Дотоод аудитор:



Г.Насанжаргал